



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/98

Улаанбаатар хот

Албан томилолтоор ажиллуулах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан томилолтоор ажиллуулах журам”-ын 2.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Төрийн өмчийн хяналт, удирдлагын хорооноос Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хамтран зохион байгуулж буй 16 дахь удаагийн “Азийн бүсийн төрийн өмчит компанийн засаглал” уулзалт, хэлэлцүүлэгт оролцуулахаар Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн А.Молорыг 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс 16-ны өдрийг дуустал албан томилолтоор ажиллуулсугай.

2.Албан томилолтоор ажиллах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Албан томилолтоор ажилласан тайланг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор танилцуулахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн А.Молорт даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132013747

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын даргын *Д.В.Оны А.* сарын *0.4*-ны
өдрийн *А/Б* дугаартай тушаалын хавсралт

“16 ДАХЬ УДААГИЙН АЗИЙН БҮСИЙН ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН
ЗАСАГЛАЛ” УУЛЗАЛТАД ОРОЛЦОХ АЛБАН ТОМИЛОЛТЫН УДИРДАМЖ

Нэг: Зорилго

“Азийн бүсийн төрийн өмчит компанийн засаглал” уулзалтын хүрээнд Азийн улс орнуудын мэргэжилтнүүдтэй төрийн өмчит компанийн өмчлөл, засаглалын асуудлаар туршлага солилцох, төрийн өмчит компанийн засаглалын бодлогын цар хүрээг үнэлэх, цаашдын хандлага, олон улсын сайн туршлагыг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-аас гаргасан тайлан илтгэл, зөвлөмжийн хүрээнд судлах, Азийн эдийн засаг дахь үр дүнтэй шинэчлэл, түүний зөвлөмжийг хөгжүүлэх, сайн туршлагыг хуваалцахад оршино.

Хоёр: Гүйцэтгэх ажлууд

1.“БНХАУ-ын төрийн өмчит компаниуд, төрийн өмчлөлийн туршлагын талаар сүүлийн жилүүдийн хөгжил” семинарт оролцох;

2.“Сонгогдсон оролцогч улс орнуудын компанийн засаглал болон өмчлөлийн туршлагатай холбоотой төрийн өмчит компанийн шинэчлэлийн сүүлийн үеийн хөгжил” семинар, хэлэлцүүлэгт оролцох;

3.“Төрийн өмчит компанийн ногдол ашгийн бодлого, туршлага” семинар, хэлэлцүүлэгт оролцох;

4.“Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн функц, үйл ажиллагааг мэргэшүүлэх, сайжруулах” семинар, хэлэлцүүлэгт оролцох;

5.“Төрийн өмчлөл ба тогтвортой хөгжлийн харилцаа” семинар, хэлэлцүүлэгт оролцох

6.“OECD-ийн зөвлөмжийн шинэчлэлийн төсөл” семинарт оролцох.